



МОНГОЛ УЛСЫН ИХ ХҮҮРЛЫН АЛБАН МЭДЭЭЛЭЛ
№7 /676/

ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХҮҮРЛЫН АЛБАН МЭДЭЭЛЭЛ

Монгол Улсын Их
Хурлын тогтоол

298

Монгол Улсын
Орлогын газрын
тогтоол

302

Монгол Улсын
Орлогын газрын
тогтоол

309

**“Ардын хувьсгал-90” медаль
бий болгох тухай**

Дүрэм шинэчлэн батлах тухай

Журам батлах тухай

**ГАРЧИГ****МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ**

71.	Хуулийн төсөл буцаах тухай	Дугаар 05	297
72.	“Ардын хувьсгал-90” медаль бий болгох тухай	Дугаар 07	298

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

73.	Дүрэм шинэчлэн батлах тухай	Дугаар 293	302
74.	Хүний хөгжил сангийн орлогын эх үүсвэрийг бүртгүүлэх талаар авах зарим арга хэмжээний тухай	Дугаар 296	308
75.	Журам батлах тухай	Дугаар 298	309
76.	Ой тэмдэглэх тухай	Дугаар 314	319

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2011 оны 01 дүгээр
сарын 27-ны өдөр

Дугаар 05

Улаанбаатар
хот

Хуулийн төсөл буцаах тухай

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.5 дахь хэсэгт заасныг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1. Монгол Улсын Засгийн газраас 2009 оны 7 дугаар сарын 03-ны өдөр Улсын Их Хуралд Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн Зар сурталчилгааны тухай хуульд нэмэлт оруулах тухай, Иргэний хуульд нэмэлт оруулах тухай, Төсвийн байгууллагын удирдлага, санхүүжилтийн тухай хуульд нэмэлт оруулах тухай, Хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэрийн төсөл боловсруулах,



оргөн мэдүүлэх журмын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслүүдийг нэгдсэн хуралдаанд оролцсон гишүүдийн олонхи хэлэлцэх шаардлагагүй гэж үзсэн тул хууль санаачлагчид нь буцаасугай.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДЭД ДАРГА**

Н.ЭНХБОЛД

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2011 оны 02 дугаар
сарын 02-ны өдөр

Дугаар 07

Улаанбаатар
хот

**"Ардын хувьсгал-90" медаль
бий болгох тухай**

Монгол Улсын Үндсэн хуулийн Хорин тавдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 13 дахь заалтыг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1."Ардын хувьсгал-90" медаль бий болгосугай.

2."Ардын хувьсгал-90" медалийн тодорхойлолтыг 1 дүгээр хавсралтаар, уг медалийг олгох журмыг 2 дугаар хавсралтаар тус тус баталсугай.

3.Энэ тогтоолыг 2011 оны 02 дугаар сарын 02-ны өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

Д.ДЭМБЭРЭЛ

Монгол Улсын Их Хурлын 2011 оны
07 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралт

**"АРДЫН ХУВЬСГАЛ-90" МЕДАЛИЙН
ТОДОРХОЙЛОЛТ**

Нэг. Медалийн хэлбэр дүрс, бэлгэдэл утгын товч тайлбар

1.1."Ардын хувьсгал-90" медаль /цаашид "медаль" гэх/ нь зүүлт, тэмдэг гэсэн хоёр хэсгээс бүрдэнэ.

1.2.Медалийн зүүлт болох дээд хэсэг нь геометрийн таван өнцөгт зохиомжтой. Таван өнцөгтийн дээд хэсэг нь Монгол Улсын Төрийн далбааны өнгө болох улаан, хөх, улаан хосолсон өнгөтэй гурван хэсгээс



бүрдэнэ. Эдгээр гурван хэсгийн дундах нь мөнх тэнгэрийн хөх, түүний хоёр талын хэсэг нь мандан бадрахын бэлгэдэл гэсэн санаа агуулсан улаан өнгөтэй байна. Гурван хэсгийг тусгаарласан босоо шугам нь нарны цацрагийг төлөөлсөн шар өнгөтэй, зүүлтний таван өнцөгтийн доод хэсэг нь нарыг төлөөлсөн шар өнгөтэй байна.

1.3.Медалийн тэмдэг болох доод хэсэг нь нарны цацраг, цэцгийн далбээ хосолсон дөрвөн зүг, найман зөвхисийг дүрсэлсэн шар өнгийн хүрээтэй байна. Хүрээний доторх хөх өнгийн дугуй дэвсгэрийн дээд хэсэгт Ардын хувьсгалын ялалтын бэлгэдэл болсон улаан өнгийн туган дээр Монгол Улсын тусгаар тогтнол, бүрэн эрхт байдал, цог хийморийг илтгэсэн алтан соёмбыг байрлуулж, түүний баруун талд нь "Ардын хувьсгал" гэсэн үгийг худам монгол бичгээр, шар өнгөөр дүрсэлнэ. Соёмбын доод талд сүүн цагаан өнгөөр "90" гэсэн тоог байрлуулна.

Хоёр. Медалийн хийц, хэмжээ

2.1.Медалийн зүүлт болох дээд хэсгийн таван өнцөгтийн өндөр нь 20 мм, Төрийн далбаа байрласан хэсгийн өргөн нь 27 мм, өндөр нь 12 мм, таван өнцөгтийн доод гурвалжингийн өндөр 8 мм, Төрийн далбааны өнгийг заагласан босоо шугам 1 мм өргөнтэй байна. Таван өнцөгтийн хөвөөний өргөн 2 мм, зүүлтний зузаан 3 мм байна.

2.2.Медалийн тэмдэг болох доод хэсгийн хүрээний диаметр урт талдаа 40 мм, богино талдаа 34 мм, хүрээний доторх дугуй хөх дэвсгэр нь 15 мм радиус бүхий тойрог байх бөгөөд Соёмбын өндөр 10 мм, "90" гэсэн тооны өндөр 4 мм байна. "Ардын хувьсгал" гэсэн үг, туг, "90" гэсэн тоо нь дэвсгэрээсээ 1,5 мм товойж гарсан байна.

2.3.Медалийн зүүлт, тэмдэг хоёрыг цагирагаар холбох бөгөөд зүүлтний ар талд медалийн дугаар, дээд хэсэгт нь түүнийг тогтоох зүүтэй байна.

2.4.Медалийн дугаарыг үнэмлэхэд бичнэ.

Монгол Улсын Их Хурлын 2011 оны
07 дугаар тогтоолын 2 дугаар хавсралт

"АРДЫН ХУВЬСГАЛ- 90" МЕДАЛЬ ОЛГОХ ЖУРАМ

1."Ардын хувьсгал-90" медалийг Монгол Улсын Ерөнхийлөгч зарлиг гарган шагнаж, үнэмлэх олгоно.

2."Ардын хувьсгал-90" медалиар эх орныхоо хөгжил дэвшлийн




төлөө үнэтэй хувь нэмэр оруулсан төр, нийгмийн нэрт зүтгэлтэн, эрдэмтэн, судлаач, зохиогч, урлаг, соёлын зүтгэлтэн, уран бүтээгч, эрхэлсэн ажилдаа амжилт гаргасан бусад хүнийг шагнана.

3. "Ардын хувьсгал-90" медалиар шагнуулах хүмүүсийн нэрсийн жагсаалтыг ажилласан жил, ажлын амжилтыг харгалзан гаргаж Монгол Улсын Ерөнхийлөгчийн 1999 оны 71 дүгээр зарлигаар баталсан "Монгол улсын цол хүртээх, одон медалиар шагнах журам"-д заасан эрх бүхий хүмүүс Монгол Улсын Ерөнхийлөгчид өргөн мэдүүлнэ.

4. "Ардын хувьсгал-90" медалийг Монгол Улсад улс төрийн нам байгуулагдсаны болон Ардын хувьсгалын 90 жилийн ойг тэмдэглэх үйл ажиллагааны хүрээнд тус тус олгоно.

5. "Ардын хувьсгал-90" медалиар нэхэн шагнахгүй.

6. "Ардын хувьсгал-90" медалийг үнэмлэхийн хамт эрх бүхий албан тушаалтан гардуулна.





"АРДЫН ХУВЬСГАЛМС"
МЕДАЛИЙН ҮНӨМӨР

"Ардын хувьсгал 90"
медалийн зураг

Овог

Нэр

Монгол Улсын Ерөнхийлөгчийн
20... оны ... дугаар сарын ...-ны
эдрийн ... дугаар зарлигаар
"Ардын хувьсгал-90" медалиар шалтга.

Монгол Улсын
Ерөнхийлөгч

Цагаангийн Зэнбидрэг

№... ..



МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2010 оны 11 дүгээр
сарын 10-ны өдөр

Дугаар 293

Улаанбаатар
хот

Дүрэм шинэчлэн батлах тухай

Дипломат албаны тухай хуулийн 24.2-т заасныг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. "Дипломат ажилтны сахилгын тусгай дүрэм"-ийг хавсралт ёсоор шинэчлэн баталсугай.
2. Энэ тогтоол гарсантай холбогдуулан "Дүрэм батлах тухай" Засгийн газрын 2001 оны 6 дугаар сарын 6-ны өдрийн 124 дүгээр тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ САЙД

С.БАТБОЛД

ГАДААД ХАРИЛЦААНЫ САЙД

Г.ЗАНДАНШАТАР

Засгийн газрын 2010 оны 293 дугаар
тогтоолын хавсралт

ДИПЛОМАТ АЖИЛТНЫ САХИЛГЫН ТУСГАЙ ДҮРЭМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Энэхүү дүрмээр дипломат ажилтны сахилгын тухай ойлголт, сахилгын үндсэн зарчим, шаардлагыг тодорхойлж, дипломат ажилтанд сахилгын шийтгэл ногдуулахтай холбогдоон харилцааг зохицуулна.

1.2. Гадаад харилцааны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага (цаашид "ГХЯ" гэх), хилийн чанад дахь Дипломат төлөөлөгчийн газар (цаашид "ДТГ" гэх)-т ажиллаж байгаа тангараг өргөсөн дипломат ажилтан энэхүү сахилгын дүрмийг чанд сахин мөрдөнө.

1.3. Дипломат ажилтан Монгол Улсын хууль тогтоомж, тэдгээрт нийцүүлэн гаргасан эрх зүйн акт болон байгууллагын дотоод журам, дипломат ажилтны сахилгын зарчим, шаардлага, дипломат ажилтны тангараг, ёс зүйн хэм хэмжээг чанд сахин биелүүлэхийг дипломат ажилтны сахилга гэнэ.

1.4. Дипломат албаны байгууллагын удирдах албан тушаалтан



нь сахилга, дэг журмыг чанд сахихыг ажилтнуудаас шаардах, түүнийг биелүүлэх нөхцөлийг бүрдүүлэх үүрэгтэй.

1.5. Сахилга, дэг журмыг тогтоох талаар үр дүнтэй арга хэмжээ аваагүй, үүргээ хэрэгжүүлж ажиллаагүй удирдах албан тушаалтан сахилгын шийтгэл хүлээнэ.

Хоёр. Дипломат ажилтны сахилгын үндсэн зарчим

2.1. Дипломат ажилтан сахилгын дараахь үндсэн зарчмыг баримтална:

2.1.1. шударга ёс, тэгш байдлыг хангаж, хууль дээдлэх;

2.1.2. хүний эрх, эрх чөлөөг хүндэтгэх;

2.1.3. үндэсний аюулгүй байдал, байгууллагын эрх ашгийг нэн тэргүүнд тавих;

2.1.4. төрийн болон байгууллага, хувь хүний нууцыг хадгалах;

2.1.5. удирдах албан тушаалтны хууль тогтоомжид нийцүүлэн гаргасан шийдвэрийг ёсчлон биелүүлэх.

Гурав. Дипломат ажилтны сахилгын шаардлага

3.1. Дипломат ажилтан нь Дипломат харилцааны тухай Венийн конвенцийг үйл ажиллагаандаа удирдлага болгож, Төрийн албаны тухай хууль, Дипломат албаны тухай хууль, ГХЯ болон ДТГ-ын хөдөлмөрийн дотоод журмаар хүлээсэн үүргээс гадна дараахь шаардлагыг сахин биелүүлнэ:

3.1.1. дипломат ажилтны нэр төрийг өндөрт өргөн, өргөсөн тангарагтаа үнэнч байж, төрийн албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээг чанд мөрдөн эх орныхоо эрх ашгийг дээдлэн төр, засгийн албан ёсны байр суурьт нийцсэн үйл ажиллагаа явуулах;

3.1.2. улс төрийн талаар төвийг сахиж, үзэл бодлоо илэрхийлэх, зөвлөлдэн нэгдэх, үг хэлэх, хэвлэн нийтлэх, шашин шүтэх, эс шүтэх эрхээ эдлэхдээ албан тушаалдаа хүндэтгэлтэй хандан төрийн албан хаагчийн ёс зүйд харш үйлдэл, эс үйлдэл гаргахгүй байх;

3.1.3. албан ёсны аливаа мэдээлэл болон албан үүрэгтэй



нь холбоотойгоор илэрхий болсон, эсхүл өөрт нь итгэмжлэн мэдэгдсэн төрийн болон байгууллага, хувь хүний нууцыг чанд хадгалж, албан ёсны мэдээллийг эрх бүхий албан тушаалтны зөвшөөрөлгүйгээр тараахгүй байх;

3.1.4. гэр бүлийн гишүүд нь суугаа орны хууль тогтоомжийг сахин биелүүлэх, дипломат эрх ямба, дархан эрхийг хувийн ашиг хонжоо олох зорилгоор ашиглахгүй байх, ёс зүйн зөрчил, хууль бус үйлдэл, эс үйлдэл гаргахгүй байх талаар арга хэмжээ авах;

3.1.5. өөрийн болон гэр бүлийн гишүүдийн дипломат болон албан паспортыг ГХЯ-нд ажиллаж байгаа тохиолдолд төрийн захиргааны асуудал хариуцсан нэгжид, хилийн чанад дахь Дипломат төлөөлөгчийн газарт ажиллаж байгаа тохиолдолд ДТГ-ын тэргүүнд хадгалуулан шаардлагатай тохиолдолд эрх бүхий албан тушаалтны зөвшөөрлөөр авч байх журмыг чанд мөрдөх;

3.1.6. Дипломат албаны тухай хууль, Төрийн албаны тухай хууль, бусад хууль тогтоомж болон дипломат албаны байгууллагын дотоод журамд заасан үүргийг чанд сахин биелүүлэх;

3.1.7. албан ажлын онцлогтой холбогдуулан гадаадын иргэн, байгууллагатай харилцах талаар тогтоосон журмыг мөрдөн ажиллах;

3.1.8. албан үүргээ гүйцэтгэх явцдаа олж мэдсэн хууль бус үйл ажиллагааны талаархи мэдээллийг нэн даруй холбогдох байгууллагад мэдээлэх;

3.1.9. гадаад улсад зорчих талаар тогтоосон журмыг мөрдөн ажиллах.

Дөрөв. Дипломат ажилтны үйл ажиллагаанд хориглох зүйл

4.1. Дипломат ажилтны үйл ажиллагаанд дараахь зүйлийг хориглоно:

4.1.1. Монгол Улсын Үндсэн хууль болон бусад хууль тогтоомжийг зөрчсөн үйлдэл, эс үйлдэл гаргах;

4.1.2. Монгол Улс, гадаад улсын төрийн байгууллагын хооронд харилцан тохирсон албан томилолт, эсхүл ГХЯ-ны эрх бүхий албан тушаалтны зөвшөөрөлгүйгээр гадаад, дотоодын аж ахуйн нэгж, байгууллага, хувь хүний зардлаар эх орондоо болон гадаадад зорчих;



4.1.3. Гадаадад томилолтоор ажиллахдаа Монгол Улсын төрийн байгууламж болон төрийн өндөр албан тушаалтны эсрэг агуулга бүхий үг хэлэх, ярилцлага өгөх, нийм утгатай материалыг хэвлэлд өгөх, нийтлүүлэх, бусдаас үг үйл ажиллагааг явуулахыг үйлдэл, эс үйлдлээр шаардах;

4.1.4. албан үүргээ гүйцэтгэж байхдаа олж мэдсэн төрийн болон байгууллага, хувь хүний нууцтай холбоотой мэдээллийг хувийн зорилгоор гэрээ, хэлцэл хийх, бусад хэлбэрээр ашиглах;

4.1.5. тогтоосон журмыг зөрчиж бэлэг дурсгалын зүйл авах, эрх бүхий албан тушаалтны зөвшөөрөлгүйгээр аж ахуйн нэгж, иргэн, улс төрийн нам болон төрийн бус байгууллагаас аливаа өргөмжлөл, шагнал авах;

4.1.6. албан тушаалын байдлаа ашиглан удирдлагадаа ажилладаг, эсхүл үйл ажиллагаанд нь хяналт тавьдаг ажилтнаар албан үүрэгтэй нь холбоогүй ажил үүрэг гүйцэтгүүлэх, хууль бус шаардлага тавих, өөртөө буюу бусдад ашиг хонжоо олох үйлдэл, эс үйлдэл хийлгэхээр шахалт үзүүлэх.

Тав. Сахилгын шийтгэл ногдуулах

5.1. Төрийн албаны тухай хуулийн 15, Дипломат албаны тухай хуулийн 11 дүгээр зүйл, дипломат ажилтны сахилга зөрчсөн, албан үүргээ биелүүлээгүй, эсхүл хангалтгүй биелүүлсэн, түүнчлэн албан тушаалын бүрэн эрхээ хэтрүүлсэн нь сахилгын шийтгэл ногдуулах үндэслэл болно.

5.2. Сахилгын шийтгэл ногдуулах үндэслэлийг зохих журмын дагуу шалган тогтооно. Шалгалтыг ГХЯ-ны эрх бүхий албан тушаалтнаас эрх олгосон дипломат ажилтан нэн даруй хийнэ.

5.3. Элчин сайд, Байнгын төлөөлөгч энэхүү дүрмийн 3, 4 дэх хэсэгт заасан сахилгын зөрчил гаргасан бол гадаад харилцааны асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн уг мэдээллийг хүлээн авснаас хойш нэг сарын дотор шалгаж, сахилгын зөрчил хүлээлгэх үндэслэлтэй нь тогтоогдвол саналаа түүнийг томилсон эрх бүхий албан тушаалтанд хүргүүлнэ. Хилийн чанад дахь ДТГ-т ажиллаж байгаа Элчин зөвлөх, Байнгын төлөөлөгчийн орлогчид гадаад харилцааны асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний тушаалаар сахилгын шийтгэл ногдуулна.

5.4. ГХЯ-ны ажилтанд Төрийн нарийн бичгийн даргын тушаалаар, хилийн чанад дахь ДТГ-т ажиллаж байгаа ДТГ-ын тэргүүн, Элчин зөвлөх, Байнгын төлөөлөгчийн орлогчоос бусад дипломат болон үйлчилгээ,



техникийн албан хаагч нарт дипломат албанаас халахаас бусад тохиолдолд Төрийн нарийн бичгийн даргын эрх шилжүүлснээр ДТГ-ын тэргүүн тушаал гаргаж сахилгын шийтгэл ногдуулна.

5.5. ДТГ-ын тэргүүн нь сахилгын шийтгэл ногдуулах үндэслэл тогтоогдсон гэж үзвэл эрх хэмжээнийхээ хүрээнд сахилгын шийтгэл ногдуулна. Хэрэв ДТГ-ын тэргүүний эрх хэмжээнд хамаарахгүй бол шалгалт хийсэн тухай илтгэх хуудас болон зөрчилд холбогдох баримт материалыг шийтгэл ногдуулах саналын хамт тухайн ажилтныг томилсон эрх бүхий албан тушаалтанд хүргүүлнэ.

5.6. Дипломат ажилтан ёс зүйн зөрчил гаргасан асуудлыг ГХЯ-ны төрийн албаны салбар зөвлөл хуралдаанаар хэлэлцэн дүгнэлт гаргана.

5.7. Дипломат ажилтныг томилсон эрх бүхий албан тушаалтан энэхүү дүрмийн 5.5-д заасан илтгэх хуудас болон зөрчилд холбогдох материал, дүгнэлт, саналтай танилцаад дараахь шийдвэрийн аль нэгийг гаргана:

5.7.1. зөрчил гаргасан нөхцөл байдал, учирсан болон учирч болзошгүй хохирол, үр дагавар зэргийг харгалзан дор дурдсан сахилгын шийтгэлийн аль нэгийг ногдуулах;

5.7.1.1. сануулах;

5.7.1.2. албан тушаалын цалингийн хэмжээг 6 сар хүртэл хугацаагаар 20 хүртэл хувиар бууруулах;

5.7.1.3. дипломат албанаас халах.

5.7.2. үндэслэлийг дахин шалгаж, нэмэлт баримт материал бүрдүүлэхээр буцаах;

5.7.3. сахилгын шийтгэл ногдуулах тухай саналыг үндэслэлгүй гэж үзэж хэрэгсэхгүй болгох.

5.8. Сахилгын шийтгэл ногдуулахад дараахь нөхцөлийг хүнд-рүүлэн авч үзнэ:

5.8.1. нэг төрлийн зөрчлийг давтан гаргасан;



5.8.2. хоёр буюу түүнээс дээш ажилтан оролцсон;

5.8.3. санаатайгаар зөрчил гаргасан болох нь тогтоогдсон;

5.8.4. сахилгын шийтгэлтэйд тооцогдох хугацаанд зөрчил давтан гаргасан.

5.9. Дараахь тохиолдлыг сахилгын ноцтой зөрчилд тооцож, дипломат албанаас хална:

5.9.1. Олон улсын эрх зүй, Монгол Улсын хууль тогтоомж, ГХЯ болон ДТГ-ын хөдөлмөрийн дотоод журам болон эрх зүйн бусад актаар хүлээсэн үүргээ үл биелүүлж, Монгол Улсын болон байгууллага, хамт олны нэр хүндэд харш үйлдэл, эс үйлдэл санаатай гаргасан, хил дамнасан хууль бус худалдаа, наймаа хийсэн, дипломат болон албан паспорт, дипломат дугаар бүхий автомашин, дипломат элчийн зар, дипломат шуудан болон ачааны хэвлэмэл хуудсыг ашиг хонжоо олох зорилгоор бусдад дамжуулсан, ашигласан, хуурамч баримт бичиг үйлдэх зэрэг зөрчил гаргасан;

5.9.2. удирдлагын зөвшөөрөлгүйгээр албан ажлын талаар нийтэд мэдээлсэн, мэдээлэл дамжуулсан, зохих зөвшөөрөлгүйгээр албаны баримт бичгийг зориулалтын бусаар ашигласан, санаатайгаар устгасан;

5.9.3. гэмт хэрэг үйлдэж шүүхээр ял шийтгүүлсэн;

5.9.4. хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр 2 буюу түүнээс дээш өдрийн ажил тасалсан.

5.10. Сахилгын нэг төрлийн зөрчилд сахилгын шийтгэлийг давхардуулан ногдуулахгүй.

5.11. Сахилгын зөрчлийг илрүүлснээс хойш 1 сар, зөрчил гаргаснаас хойш 6 сараас илүү хугацаа өнгөрсөн бол сахилгын шийтгэл ногдуулахгүй.

5.12. Сахилгын шийтгэл ногдуулсан өдрөөс хойш 1 жилийн дотор дахин сахилгын шийтгэл хүлээгээгүй бол сахилгын шийтгэлгүйд тооцно.

5.13. Дипломат ажилтанд сахилгын шийтгэл ногдуулсан тухай шийдвэрийг өөрт нь танилцуулж, хувийн хэрэгт нь хадгална. Шаардлагатай гэж үзвэл хамт олонд нь мэдээлж болно.



5.14. Дипломат ажилтанд дипломат албанаас халах шийтгэл ногдуулсан тохиолдолд энэ нь түүний дипломат албанд эгүүлэн авахаас татгалзах үндэслэл болно.

5.15. Дипломат ажилтан сахилгын шийтгэл ногдуулсан тухай шийдвэрийг үндэслэлгүй гэж үзвэл энэ тухай гомдлоо тухайн шийдвэрийг мэдсэн өдрөөс хойш 1 сарын дотор дээд шатны албан тушаалтан, холбогдох бусад байгууллагад гаргаж болно. Сахилгын шийтгэлийн талаар гомдол гаргасан нь түүнийг биелүүлэхээс татгалзах үндэслэл болохгүй.

5.16. Сахилгын шийтгэл ногдуулсан нь түүнийг эрүүгийн болон бусад хариуцлагаас чөлөөлөх үндэслэл болохгүй.

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2010 оны 11 дүгээр
сарын 10-ны өдөр

Дугаар 296

Улаанбаатар
хот

Хүний хөгжлийн сангийн орлогын эх үүсвэрийг бүрдүүлэх талаар авах зарим арга хэмжээний тухай

Хүний хөгжлийн сангийн тухай хуулийн 3.2.4-т заасныг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. Хүний хөгжлийн сангийн 2011 оны орлогын эх үүсвэрийг бүрдүүлэх зорилгоор 310.6 (гурван зуун арван тэрбум зургаан зуун сая) тэрбум төгрөгийн эх үүсвэрийг урьдчилгаа төлбөр болон зээл хэлбэрээр бүрдүүлэх арга хэмжээ авахыг Төрийн өмчийн хороо (Д.Сугар), "Эрдэнэс МГЛ" ХХК (Б.Энэбиш)-д даалгасугай.

2. Хүний хөгжлийн сангийн эх үүсвэрийг бүрдүүлэхтэй холбогдуулан "Эрдэнэс МГЛ" ХХК-тай урьдчилгаа төлбөрийн гэрээ байгуулах тохиолдолд Засгийн газрыг төлөөлж гарын үсэг зурахыг Сангийн сайд С.Баярцогтод зөвшөөрсүгэй.

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ САЙД

С.БАТБОЛД

САНГИЙН САЙД

С.БАЯРЦОГТ

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2010 оны 11 дүгээр
сарын 17-ны өдөр

Дугаар 298

Улаанбаатар
хот

Журам батлах тухай

Өрсөлдөөний тухай хуулийн 15.1.6-д заасныг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. “Зүй ёсны монополь болон давамгай байдалтай аж ахуй эрхлэгчийг тогтоох журам”-ыг хавсралт ёсоор баталсугай.

2. Энэ тогтоол гарсантай холбогдуулан “Журам батлах тухай” Засгийн газрын 2005 оны 10 дугаар сарын 7-ны өдрийн 214 дүгээр тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ САЙД**

С.БАТБОЛД

**МОНГОЛ УЛСЫН ТЭРГҮҮН
ШАДАР САЙД**

Н.АЛТАНХУЯГ

Засгийн газрын 2010 оны 298 дугаар
тогтоолын хавсралт

ЗҮЙ ЁСНЫ МОНОПОЛЬ БОЛОН ДАВАМГАЙ БАЙДАЛТАЙ АЖ АХУЙ ЭРХЛЭГЧИЙГ ТОГТООХ ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Аж ахуй эрхлэгчийг тодорхой бараа бүтээгдэхүүний зах зээл дээр зүй ёсны монополь болон давамгай байдалтай эсэхийг судалж тогтоох, бүртгэх, хяналт тавихтай холбогдсон харилцааг энэхүү журмаар зохицуулна.

1.2. Энэ журамд хэрэглэсэн дараахь нэр томъёог дор дурдсан утгаар ойлгоно:

1.2.1. “харилцан орлох бараа бүтээгдэхүүн” гэж зориулалт, хэрэглээ, техникийн тодорхойлолт, үнэ, худалдах болон худалдан авах нөхцөл, бусад хэмжүүрүүдийг адилтгаж болох, хэрэглээг нь орлуулж болох бараа бүтээгдэхүүнийг;



1.2.2. "зах зээлд эзлэх хувь" гэж тухайн зах зээлд аж ахуй эрхлэгчийн дангаараа буюу бусад этгээдтэй хамтран нийлүүлсэн, эсхүл худалдан авсан бараа бүтээгдэхүүний эзлэх хувийг.

Хоёр. Зүй ёсны монополь болон давамгай байдалтайг тогтоох

2.1. Тодорхой бараа бүтээгдэхүүний зах зээл дээр аж ахуй эрхлэгчийн зүй ёсны монополь байдалтайг тогтоохдоо дараахь хүчин зүйлийг харгалзан үзнэ:

2.1.1. бараа бүтээгдэхүүнийг хэрэглэгчид дамжуулах, түгээх сүлжээ, дэд бүтэц, технологийн онцлогоос шалтгаалж тухайн бараа бүтээгдэхүүнийг өөр бараа бүтээгдэхүүнээр орлуулах боломжгүй эсэх;

2.1.2. тухайн бараа бүтээгдэхүүний зах зээлд шинээр аж ахуй эрхлэгч нэвтрэн ороход эдийн засгийн болон хууль, эрх зүйн боломж хязгаарлагдмал эсэх;

2.1.3. холбогдох бусад хүчин зүйл.

2.2. Тодорхой бараа бүтээгдэхүүний зах зээл дээр аж ахуй эрхлэгчийн давамгай байдалтайг дараахь үе шатаар тогтооно:

2.2.1. бараа бүтээгдэхүүний хүрээг тодорхойлох;

2.2.2. зах зээлийн газар зүйн хил хязгаарыг тогтоох;

2.2.3. зах зээлийн төвлөрлийг тооцох;

2.2.4. зах зээлийн хүчийг тодорхойлох.

Гурав. Бараа бүтээгдэхүүний хүрээг тодорхойлох

3.1. Бараа бүтээгдэхүүний хүрээг тодорхойлоход дараахь хүчин зүйлийг харгалзан үзнэ:

3.1.1. эдийн засгийн үйл ажиллагааны олон улсын стандарт ангилал, тухайн бараа бүтээгдэхүүний стандарт, код, бусад холбогдох мэдээлэл;

3.1.2. зах зээлийн судалгаа;

3.1.3. шаардлагатай бол хэрэглэгчдээс авсан санал



асуулга, шинжээчийн дүгнэлт;

3.1.4. бараа бүтээгдэхүүний харилцан орлох байдлыг тогтоох боломж бүхий бусад хүчин зүйл.

3.2. Бараа бүтээгдэхүүний хүрээг тодорхойлох нь бараа бүтээгдэхүүнийг хэрэглээ, зориулалтаар нь ангилж, тэдгээрийн харилцан орлох бараа бүтээгдэхүүний бүлгийг тодорхойлоход чиглэгдсэн үйл ажиллагаа бөгөөд дараахь үе шаттай байна:

3.2.1. эдийн засгийн үйл ажиллагааны олон улсын стандарт ангилал, тухайн бараа бүтээгдэхүүний стандарт, код, бусад холбогдох мэдээллийг үндэслэн тухайн бараа бүтээгдэхүүнийг хэрэглээ, зориулалтаар нь ангилах;

3.2.2. сонгосон ангиллын бараа бүтээгдэхүүнийг хэрэглээ болон нийлүүлэлт талаас нь орлох бараа бүтээгдэхүүн байгаа эсэхийг судлан харилцан орлох бараа бүтээгдэхүүний хүрээг тодорхойлох;

3.2.3. хэрэв бараа бүтээгдэхүүний хэрэглээ, харилцан орлох байдлын талаар шууд дүгнэлт гаргах боломжгүй бол хэрэглэгч, үйлдвэрлэгч, өрсөлдөгчдөөс санал асуулга авах, ярилцлага хийх замаар бараа бүтээгдэхүүний хэрэглээ, харилцан орлох байдлын талаар дүгнэлт гаргаж болно. Судлагдаж байгаа зах зээлийн нөхцөл байдлаас шалтгаалан санал асуулга, ярилцлагын асуултуудыг тодорхойлох бөгөөд түүнд дараахь асуудлыг зайлшгүй тусгана:

3.2.3.1. судлагдаж байгаа бараа бүтээгдэхүүнийг ямар зориулалтаар ашиглаж байгаа;

3.2.3.2. уг зориулалтаар өөр ямар бараа бүтээгдэхүүнийг ашиглаж болох;

3.2.3.3. тухайн бараа бүтээгдэхүүний үнэ нь мэдэгдэхүйц хэмжээ /50 хувиас дээш/-гээр 6 сараас дээш хугацаагаар өсвөл хэрэглэгч түүнийг орлох бараа бүтээгдэхүүн рүү шилжих эсэх, үнэ нь буурвал өөр худалдан авагчид худалдах эсэх;

3.2.4. хэрэглэгч, үйлдвэрлэгч, өрсөлдөгчдөөс авах санал асуулга, судалгааг маркетингийн судалгааны арга зүйд үндэслэн хийх бөгөөд түүний мэдээ, мэдээллийн боловсруулалтад статистик судалгааны арга зүйг ашиглан дүн шинжилгээ хийнэ.

3.3. Шаардлагатай тохиолдолд бараа бүтээгдэхүүний харилцан



орлох байдлын талаар шинжээчийн дүгнэлт гаргуулан баталгаажуулж болно. Энэхүү дүгнэлтэнд судалж байгаа бараа бүтээгдэхүүний зориулалт, харилцан орлох чадварын талаархи мэдээллийг тусгасан байна.

Дөрөв. Зах зээлийн газар зүйн хил хязгаарыг тогтоох

4.1. Зах зээлийн газар зүйн хил хязгаарыг тогтооход дараахь хүчин зүйлийг харгалзан үзнэ:

4.1.1. өрсөлдөгч, хэрэглэгч, худалдан авагчийн байршил, бараа бүтээгдэхүүний борлуулалт хийгдэж байгаа нутаг дэвсгэр;

4.1.2. бараа бүтээгдэхүүний тээвэрлэлтийн нөхцөл, байдлын судалгаа;

4.1.3. тээвэрлэлтийн дундаж зардал болон нийт зардалд нөлөөлөх гол хүчин зүйлийн талаархи мэдээлэл;

4.1.4. тухайн бараа бүтээгдэхүүнийг өөр зах зээлээс худалдан авах, эсхүл өөр зах зээлд нийлүүлэх боломж эдийн засгийн хувьд хязгаарлагдмал болохыг харуулах бусад хүчин зүйлс.

4.2. Зах зээлийн газар зүйн хил хязгаарыг тогтоох нь тухайн бараа бүтээгдэхүүнийг адил төрлийн өөр зах зээлээс худалдаж авах, эсхүл нийлүүлэх эдийн засгийн боломж хязгаарлагдмал нутаг дэвсгэрийг тогтоох үйл ажиллагаа бөгөөд дараахь үе шаттай байна:

4.2.1. өрсөлдөгчдийн үйлдвэр, агуулах, борлуулалтын газрын байршлыг тогтоох;

4.2.2. хэрэглэгчдийн эсхүл худалдан авагчдын байршлыг тогтоох;

4.2.3. бараа бүтээгдэхүүний борлуулалт болон түгээлтийн сувгийг тодорхойлох;

4.2.4. дээрх мэдээлэлд харьцуулалт, дүн шинжилгээ хийж, судлагдаж байгаа нутаг дэвсгэрийг тусгай газар зүйн хил хязгаарт хуваах;

4.2.5. хуваасан газар зүйн хил хязгаарын хооронд тухайн бараа бүтээгдэхүүнийг тээвэрлэх нөхцөл, тээвэрлэлтийн дундаж зардал, түүнд нөлөөлөх хүчин зүйл зэргийг судалж, хил хязгаарын хооронд бараа бүтээгдэхүүн харилцан шилжүүлэх нь үнэ болон шинж чанарт нь



мэдэгдэхүйц нөлөөлөхгүй гэж үзвэл тухайн газар зүйн хил хязгаарын хооронд өрсөлдөөний нөхцөл байдал ялгаагүй хэмээн үзэж нэг газар зүйн хил хязгаарт авч үзнэ.

Тав. Зах зээлийн төвлөрлийг тооцох

5.1. Зах зээлийн төвлөрлийг тооцохдоо дараахь хүчин зүйлийг харгалзан үзнэ:

5.1.1. аж ахуй эрхлэгчийн зах зээлд эзлэх хувь

Аж ахуй эрхлэгчийн тухайн бараа бүтээгдэхүүний үйлдвэрлэл, борлуулалт, худалдан авалтын хэмжээг бараа бүтээгдэхүүний хүрээ, газар зүйн хил хязгаараар тодорхойлогдсон зах зээлийн үйлдвэрлэл, борлуулалт, худалдан авалтын нийт хэмжээнд харьцуулж тодорхойлно.

Бараа бүтээгдэхүүний үйлдвэрлэл, борлуулалт, худалдан авалтын хэмжээг дор дурдсан зүйлийг харгалзаж ойролцоогоор тооцож болно:

1. Биет хэмжээ.

2. Мөнгөн дүн.

3. Шаардлагатай бол үйлдвэрлэл, борлуулалт, худалдан авалтын хүчин чадал.

Аж ахуй эрхлэгчийн зах зээлд эзлэх хувийг дараахь 3 аргын аль нэгээр тодорхойлно:

1. Бараа бүтээгдэхүүний үйлдвэрлэл, борлуулалт, худалдан авалтын хэмжээгээр /тухайн аж ахуйн нэгжийн зах зээлд борлуулсан бүтээгдэхүүний хэмжээ мэдэгдэхгүй бол үйлдвэрлэлийн хэмжээгээр орлуулан тооцож болно/:

$$НБ = B_1 + B_2 + B_3 + \dots + B_n; \quad ЗЗЭХ_n = \frac{B_n}{НБ} \times 100\%$$

$$НХА = ХА_1 + ХА_2 + ХА_3 + \dots + ХА_n; \quad ЗЗЭХ_n = \frac{ХА_n}{НХА} \times 100\%$$

B_n , $ХА_n$ - м аж ахуй эрхлэгчийн зах зээлд үйлдвэрлэсэн, борлуулсан, эсхүл худалдан авсан бараа бүтээгдэхүүний хэмжээ



$НБ$, $НХА$ - бүтээгдэхүүн үйлдвэрлэлт, борлуулалт, худалдан авалтын нийт хэмжээ

$ЗЗЭХ_u$ - м аж ахуй эрхлэгчийн зах зээлд эзлэх хувь

2. Балансын аргаар:

$$H = BH_1 + Y + O - Г - BH_2; \quad ЗЗЭХ_u = \frac{B_u}{H} \times 100\%$$

B_u - м аж ахуй эрхлэгчийн зах зээлд нийлүүлсэн эсхүл худалдан авсан бараа бүтээгдэхүүний хэмжээ

$BH_1; BH_2$ тухайн хугацааны эхэн ба төгсгөлийн үеийн бүтээгдэхүүний нөөц

Y -тухайн хугацаанд судлагдаж байгаа нутаг дэвсгэрт үйлдвэрлэгдсэн бараа бүтээгдэхүүний тоо хэмжээ

O -судалж байгаа нутаг дэвсгэрийн зах зээлд гаднаас орж ирж байгаа бараа бүтээгдэхүүний тоо хэмжээ

$Г$ -судалж байгаа нутаг дэвсгэрээс гадагшаа гаргасан бараа бүтээгдэхүүний тоо хэмжээ

H -бараа бүтээгдэхүүний нийт нийлүүлэлт

$ЗЗЭХ_u$ - м аж ахуй эрхлэгчийн зах зээлд эзлэх хувь

3. Зах зээлийн хэрэгцээ эсхүл нийлүүлэх боломжоор:

$$ЗЗЭХ_u = \frac{B_u}{X} \times 100\%$$

B_u - м аж ахуй эрхлэгчийн зах зээлд нийлүүлсэн эсхүл худалдан авсан бараа бүтээгдэхүүний хэмжээ



X - тухайн зах зээлийн хэрэгцээ, эсхүл нийлүүлэх боломж

$ЗЗЭХ_m$ - m аж ахуй эрхлэгчийн зах зээлд эзлэх хувь

5.1.2. зах зээл дээрх аж ахуй эрхлэгчдийн тоо.

5.2. Зах зээлийн төвлөрлийг тооцооноор бараа бүтээгдэхүүний үйлдвэрлэлт, борлуулалт, худалдан авалт цөөн хэдэн аж ахуй эрхлэгчдэд төвлөрсөн эсэхийг тогтоож дүгнэлт гаргах боломжтой болох бөгөөд үүний тулд хамгийн өргөн хэрэглэгддэг Херфиндал-Хершманы индекс (ХХИ)-ийг болон бусад холбогдох аргачлал, тооцооллыг ашиглаж болно.

$$ХХИ = \sum_{m=1}^n ЗЗЭХ_m^2$$

$ЗЗЭХ_m$ - m дүгээр аж ахуй эрхлэгчийн зах зээлд эзлэх хувь;

n - зах зээл дээрх аж ахуй эрхлэгчдийн тоо.

$ХХИ < 1000$ бол тухайн зах зээлийг хангалттай тооны өрсөлдөгчтэй төвлөрөл байхгүй гэж үзнэ.

$1000 < ХХИ < 1800$ бол тухайн зах зээлийг дунд зэргийн төвлөрөлтэй гэж үзнэ.

$ХХИ > 1800$ байгаа тохиолдолд тухайн зах зээлд төвлөрлийн түвшин өндөр буюу өрсөлдөөн хязгаарлагдмал гэж үзнэ.

Зургаа. Зах зээлийн хүчийг тодорхойлох

6.1. Тухайн аж ахуй эрхлэгчийн зах зээлд үзүүлэх хүчийг тодорхойлохдоо дараахь хүчин зүйлийг харгалзан үзнэ:

6.1.1. аж ахуй эрхлэгчийн тухайн бараа бүтээгдэхүүнийг үйлдвэрлэх буюу борлуулах хүчин чадал;

6.1.2. аж ахуй эрхлэгчийн тухайн зах зээл болон бусад зах зээлд эзлэх хувь;

6.1.3. аж ахуй эрхлэгчийн технологи, хөрөнгө оруулалт, санхүүгийн байдал;

6.1.4. зах зээлд нэвтрэх саад;



6.1.4.1. тухайн зах зээлд шинээр аж ахуй эрхлэгч нэвтрэн ороход хууль эрх зүйн буюу ямар нэг зохицуулалтын хязгаарлалт бий эсэх;

6.1.4.2. худалдан авагч байнгын нийлүүлэгчдийнхээ эсхүл нийлүүлэгч байнгын худалдан авагчийнхаа хэвшмэл болсон үйлчилгээ, төлөв байдлаас татгалзаж өөр нийлүүлэгч эсхүл худалдан авагчтай хамтрах сонирхол байгаа эсэх;

6.1.4.3. шинээр аж ахуй эрхлэгч тухайн зах зээлд нэвтрэн ороход технологи, хөрөнгө оруулалт, санхүүгийн хувьд боломжтой эсэх;

6.1.4.4. тухайн зах зээлд үйл ажиллагаа явуулж буй аж ахуй эрхлэгчдийн зүгээс шинээр аж ахуй эрхлэгч нэвтрэн ороход ямар нэгэн хязгаарлалт хийх боломж байгаа эсэх;

6.1.5. зах зээлийг тэнцвэржүүлэх чадвар, нөлөөлөл;

6.1.6. зах зээлийн бусад шинж чанар.

6.2. Зах зээлд үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуй эрхлэгчийн байр суурь, хүч, нөлөөллийг тодорхойлохдоо Лернерийн индекс болон олон улсын туршлага, холбогдох бусад арга аргачлалыг ашиглаж болно.

6.3. Лернерийн индексийн гол утга нь ашгийн нормын хэр хэмжээг тодорхойлоход оршино.

$$J_1 = \frac{P_m - M_c}{P_m}$$

J_1 - Лернерийн индекс

P_m - Монополь үнэ /таваарын үнэ/

M_c - Ахиуц зардал

6.4. Зарим нөхцөлд ахиуц зардлыг тодорхойлох боломжгүй бол Лернерийн индексийг дундаж зардлаар бодож гаргаж болно.

$$J_1 = \frac{P_m - AC}{P_m}$$

AC - дундаж зардал

Долоо. Зүй ёсны монополь болон давамгай байдалтай
аж ахуй эрхлэгчийн бүртгэл, хяналт

7.1. Өрсөлдөөний тухай хууль болон энэ журмын дагуу аливаа аж ахуй эрхлэгч зүй ёсны монополь болон давамгай байдалтай болох нь тогтоогдсон бол шударга өрсөлдөөний асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага тухайн аж ахуй эрхлэгчийг зүй ёсны монополь болон давамгай байдалтай болохыг баталгаажуулсан шийдвэр гаргаж, бүртгэнэ.

7.2. Зүй ёсны монополь аж ахуй эрхлэгч жил бүрийн I улиралд багтаан өмнөх жилийн санхүүгийн тайлан, зах зээлийн байдалд хийсэн өөрийн судалгаа, саналаа шударга өрсөлдөөний асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагад ирүүлнэ.

7.3. Энэ журмын 7.2-т заасны дагуу ирүүлсэн тайлан, судалгаа, саналыг шударга өрсөлдөөний асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага энэ журмын 7.4-т заасан эх сурвалжид үндэслэн судалж үзээд тухайн аж ахуй эрхлэгчийг зүй ёсны монополь байдлаа алдсаныг тогтоож, "Зүй ёсны монополь аж ахуй эрхлэгчийн бүртгэл"-ээс хасах тухай шийдвэр гаргана.

7.4. Аж ахуй эрхлэгчийн давамгай байдалтайг болон давамгай байдлаа алдсаныг тогтоох мэдээллийн эх сурвалж нь шударга өрсөлдөөн, гааль, татварын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага, статистикийн төв байгууллага болон бусад төрийн байгууллагаас гаргасан мэдээ, мэдээлэл, өмнө нь хийсэн ажлын тайлан, судалгаа, шинжилгээний дүгнэлт болон зохих журмын дагуу бэлтгэсэн санал асуулга, ярилцлага, баримт бичгүүд, судалгаа, тухайн аж ахуйн нэгжийн цахим хуудаст тавигдсан мэдээлэл, санхүүгийн мэдээ, тайлан зэрэг байна.

7.5. Давамгай байдалтай аж ахуй эрхлэгч жил бүрийн I улиралд багтаан өнгөрсөн жилийн санхүүгийн баталгаат тайлан, зах зээлийн байдалд хийсэн өөрийн судалгаа, саналаа шударга өрсөлдөөний асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагад ирүүлнэ.

7.6. Энэ журмын 7.5-д заасны дагуу ирүүлсэн тайлан, судалгаа, саналыг шударга өрсөлдөөний асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага мөн журмын 7.4-т заасан эх сурвалжид үндэслэн судалж үзээд тухайн аж ахуй эрхлэгчийг дараахь тохиолдолд давамгай байдлаа алдсаныг хүлээн зөвшөөрч "Давамгай байдалтай аж ахуй эрхлэгчийн



бүртгэл"-ээс хасах тухай шийдвэр гаргана:

7.6.1. шударга өрсөлдөөний асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагаас тухайн аж ахуй эрхлэгчийг давамгайл байдлаа алдсаныг тогтоосон;

7.6.2. аж ахуй эрхлэгч өөрийгөө давамгайл байдалтай биш гэдгээ хууль болон энэ журмын дагуу судалсны үндсэн дээр нотолж, түүнийг нь шударга өрсөлдөөний асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага хүлээн зөвшөөрсөн;

7.6.3. давамгайл байдалтай аж ахуй эрхлэгч хуульд заасны дагуу өөрчлөн байгуулагдсан.

7.7. Аж ахуй эрхлэгчийн зүй ёсны монополь болон давамгайл байдалтай, тэр байдлаа алдсаныг тогтоосон шийдвэр, бүртгэлийн мэдээллийг шударга өрсөлдөөний асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын цахим хуудаст байрлуулсан олон нийтэд мэдээлж, тухайн салбарын асуудлыг хариуцсан төрийн захиргааны төв болон төрийн захиргааны байгууллага, зүй ёсны монополь болон давамгайл байдалтай нь тогтоогдсон аж ахуй эрхлэгчид тухай бүр албан бичгээр мэдэгдэж байна.

Найм. Зүй ёсны монополь болон давамгайл байдалтай
аж ахуй эрхлэгчийн эрх, үүрэг

8.1. Зүй ёсны монополь болон давамгайл байдалтай болохыг тогтоосон үндэслэлийг тухайн аж ахуй эрхлэгч шударга өрсөлдөөний асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагаас шаардан авах эрхтэй.

8.2. Зүй ёсны монополь болон давамгайл байдалтай аж ахуй эрхлэгч нь шударга өрсөлдөөний асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагаас шаардсан мэдээ, мэдээлэл, баримт бичиг, аудитаар баталгаажуулсан санхүүгийн тайланг энэ журамд заасан болон шаардсан хугацаанд гаргаж өгөх үүрэгтэй.

Ес. Хариуцлага, маргаан шийдвэрлэх

9.1. Энэхүү журмыг зөрчсөн гэм буруутай этгээдэд холбогдох хууль тогтоомжид заасны дагуу хариуцлага хүлээлгэнэ.

9.2. Энэхүү журамтай холбогдон гарсан маргааныг Өрсөлдөөний тухай хуульд заасны дагуу шийдвэрлэнэ.

**МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ**

2010 оны 12 дугаар
сарын 1-ний өдөр

Дугаар 314

Улаанбаатар
хот

Ой тэмдэглэх тухай

"Монголын тулгар төрийн 2220 жилийн ойг тэмдэглэх тухай" Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2010 оны 216 дугаар зарлигийг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас **ТОГТООХ** нь:

1. Хүннү гүрэн байгуулагдсаны 2220 жилийн ойг 2011 оны туршид тэмдэглэхээр тогтсугай.

2. Хүннү гүрэн байгуулагдсаны 2220 жилийн ойг тэмдэглэн өнгөрүүлэх ажлыг зохион байгуулах Үндэсний хорооны бүрэлдэхүүнийг хавсралт ёсоор баталсугай.

3. Хүннү гүрэн байгуулагдсаны 2220 жилийн ойг тэмдэглэхэд төсвөөс шаардагдах зардлыг Монгол Улсын 2011 оны төсөвт тусгагдсан их ойннуудыг тэмдэглэн өнгөрүүлэх арга хэмжээний зардалд багтаан зохион байгуулахыг Үндэсний хороо (Е.Отгонбаяр)-нд зөвшөөрсүгэй.

4. Энэ тогтоол гарсантай холбогдуулан Засгийн газрын 2010 оны 7 дугаар сарын 7-ны өдрийн 172 дугаар тогтоолоор баталсан "Түүхэн үйл явдлын ой, тэмдэглэлт өдрийг тэмдэглэх, гавьяат үйлстнийг алдаршуулах, дурсгалыг нь мөнхжүүлэх журам"-ын 3.1 дэх хэсгийг дор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

"3.1. Энэ журмын 2.1.1-2.1.6-д заасан их ойг тэмдэглэн өнгөрүүлэх хороог Засгийн газар байгуулна. Хороо нь ой тэмдэглэн өнгөрүүлэх арга хэмжээний төлөвлөгөө, төсвийн төслийг боловсруулж, Засгийн газарт оруулж шийдвэрлүүлнэ."

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ САЙД**

С.БАТБОЛД

**БОЛОВСРОЛ, СОЁЛ, ШИНЖЛЭХ
УХААНЫ САЙД**

Е.ОТГОНБАЯР



Засгийн газрын 2010 оны 314 дүгээр
тогтоолын хавсралт

**ХҮННҮ ГҮРЭН БАЙГУУЛАГДСАНЫ 2220 ЖИЛИЙН
ОЙГ ТЭМДЭГЛЭН ӨНГӨРҮҮЛЭХ АЖЛЫГ ЗОХИОН
БАЙГУУЛАХ ҮНДЭСНИЙ ХОРООНЫ БҮРЭЛДЭХҮҮН**

Дарга

-Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайд

Дэд дарга

-Шинжлэх ухааны академийн ерөнхийлөгч

Гишүүд:

- Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дэд дарга;
- Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газрын дарга (зөвшилцсөнөөр);
- Сангийн яамны Төрийн нарийн бичгийн дарга;
- Гадаад харилцааны яамны Төрийн нарийн бичгийн дарга;
- Монгол Улсын Ерөнхийлөгчийн Нийгмийн бодлогын зөвлөх (зөвшилцсөнөөр);
- Боловсрол, соёл, шинжлэх ухааны яамны Шинжлэх ухаан, технологийн газрын дарга;
- Батлан хамгаалах яамны Төрийн захиргаа, удирдлагын газрын дарга;
- Архангай аймгийн Засаг дарга;
- Улаанбаатар хотын Засаг даргын Г орлогч;
- Шинжлэх ухааны академийн Түүхийн хүрээлэнгийн захирал;
- Шинжлэх ухааны академийн Археологийн хүрээлэнгийн захирал;
- Монгол Улсын Их Сургуулийн Эрдэм шинжилгээ эрхэлсэн дэд захирал.

Нарийн бичгийн дарга

-Боловсрол, соёл, шинжлэх ухааны яамны Соёл, урлагийн бодлогын газрын дарга

Хаяг:

"Төрийн мэдээлэл" эмхтгэлийн редакци
Улаанбаатар-12, Төрийн ордон 124 тоот

И-мэйл: turin_medeelal@parliament.mn

Утас: 262429, 329612

Хэвлэлийн хуудас 1.5

Индекс: 14003



Улсын Их Хурлын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Хурал
Утас: 229487